



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663, Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261885, Цахим хаяг: Sambuunyamyia@audit.gov.mn

Ахлах аудитор: Р.Цолмон


Утас: 91918652, Цахим хаяг: rtslmn2003@yahoo.com

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Конфиденсе Аудит ХХК

Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Конфиденсе Аудит ХХК, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо,
Жуулчины гудамж, Капитал центр 10 давхар 1005 тоот

Улаанбаатар хот



АГУУЛГА

2. Аудитын тайлан

2.1 Оршил

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл, зорилго, талуудын хүлээх хариуцлага

2.3 Компанийн зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн

2.5 Дотоод хяналт

2.6 Төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2.7 Шилэн дансны мэдээлэл

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

2.10 Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэлгээрийг шийдвэрлэсэн талаар

2.11 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2.16 Материаллаг байдлын суурь сонгосон үндсэслэл, тайлбар

2.17 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

3. Менежментийн захидал

4. Санхүүгийн тайлангууд

5. Залруулгын хүснэгт

6. Асуудлын бүртгэл

7. Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл

8. Хураангуй тайлан

9. Санхүүгийн тайлан, тодруулга



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД
ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛОЛТ
НЭВТРҮҮЛЭХ ТӨВ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Р.ЦОГТБААТАР ТАНАА

2018.03.15 № 06/742
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" ТӨААТҮГ-ын 2017 оны оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0315SAG70.Docx



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

"Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. P. 13

Ц.НАРАНЧИМЭГ

УХАА0122

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2018\0315SAG70.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын захирал Р.Цогтбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, аудит хийгдсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, тайлан материалаа цаг тухай бүрт гаргаж өгч байх, дүрмийн сангийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд цаг тухай бүрт бүртгүүлж байх, бараа материал үндсэн хөрөнгийг ангилалийн дагуу бүртгэж байх талаар зөвлөмж өгөв.


Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий удиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан, аудитад баталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл, зорилго, талуудын хүлээх хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18 зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд “Конфиденсе аудит” ХХК аудитыг хийлээ. САГ-2018/108/СТА-ТӨҮГ

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого холбогдох хууль, заавар, журмын хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын 2017оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт/СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар,



журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн завсар үеийн аудит хийгдээгүй, тайлант оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 19-нөөс 2018 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн аудитын багийн ахлах аудитор П.Ариунаа, аудитор Г.Шинэцэцэг, туслах ажилтан Б.Цэцэгсайхан нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-8/


“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 12-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 12-ноос 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 16-нд “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын захиралд гардуулна.

2.3 Компанийн зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай, Тариалангийн тухай, Таримал ургамалын үр, сортын тухай хуулиуд болон бусад эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль НББ-ийн хууль болон зарим заавар журам, түүнд нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дотоод журам, зааварт ямар нэг өөрчлөлт ороогүй.

Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны хүрээнд довшилтод дэвшилтэд техник, технологи дамжуулах, нэвтрүүлэх, зуучлах, эрэлтэд нийцсэн



сургалт зохион байгуулах, судалгаа хийх, эрдэм шинжилгээний шинэ бүтээл туурвих, мэргэжлийн зөвөлгөө, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг.

Тус байгууллага нь БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийн агентлаг дах Копио Монгол төвөөс хэрэгжүүлж буй төслийг гүйцэтгэгч хийж байна. Үүнд:

1. “Олон наст тэжээлийн ургамал, царгас тариалах, тэжээлийн ургамлын үр үржүүлгийн загвар аж ахуй байгуулах” төслийг 2014 оноос 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдөр хүртэл хэрэгжүүлсэн,
2. “Хүнс хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх” төсөл 2015 оноос 2017 оны 12 дугаар сар хүртэл хэрэгжүүлсэн,
3. “Сургалт, туршилт, үйлдвэрлэлийн загвар төв байгуулах” төслийг 2015 оноос хэрэгжүүлж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:


Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх захирлын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд балансын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-3/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 26 горим сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-7/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх ХХААХҮЯ-наас боловсруулсан 2016 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн А/92 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн



мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolous санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ -ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон.

2.6 Төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2.7 Шилэн дансны мэдээлэл


Шилэн дансны тухай хуулийн дагуу үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд (shilendans.gov.mn) вэб хуудсанд мэдээллийг байршуулсан байна. 2017 оны 1 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл гарсан зардлын 119.3 сая төгрөгийн гүйцэтгэлээс 55.3 сая төгрөгийн зардлын гүйлгээг шилэн дансны мэдээлэлд оруулаагүй байна.

2.8 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан 26 горим, сорил гүйцэтгэв.

2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх үйлдвэрлэлийн хяналт, авлага, сургалт семинар мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, бусад орлого, авлага, сургалт семинар



зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

2.10 Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэлгээрийг шийдвэрлэсэн талаар

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын 2017 онд завсрын аудитаар хийгдээгүй байна.

2.11 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаанууд илэрсэн бөгөөд тэдгээрийг залруулсан боловч дараах алдаа зөрчлүүд байна. Үүнд:

1. Санхүүжүүлэгч “Копиа монгол төв”-д шаардлагатай тайлангуудыг дутуу гаргаж өгсөн. Үүнээс шалтгаалан тус байгууллагаас тайлан гүйлгээг ирүүлэх гомдол гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүжүүлэгч байгууллагатайгаа тооцоо нийлж, шаардлагатай баримтыг гаргаж өгөх талаар удирдлагад зөвлөмж өгөх.

2. Санхүүгийн тайланд эздийн өмчийн дүн 219.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шаардлагатай талаар удирдлагад зөвлөмж өгөх.

3. ХААҮШУОНТөв ТӨААТҮГ байрлаж байгаа байрныхаа 5 дугаар давхрыг түрээслүүлж тайлант онд 33.3 сая төгрөгийн орлого олсон байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 102 дугаар тогтоолын 2 дугаар хэсэгт “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж заасныг зөрчиж 30 хувь болох 9.9 сая төгрөгийг өглөгөөр тусгаж, төсөвт төвлөрүүлээгүй байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь: Түрээслүүлэгч-түрээслэгчийн хооронд байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг батлагдсан загварын дагуу баталгаажуулан, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах"-ыг шаардсан албан шаардлага өгөх.

4. Үндсэн хөрөнгийн шинжтэй 11.0 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд ангилал буруу бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгийг зөв ангилж бүртгэх талаар зөвлөмж өгөх.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

Тайлант онд 2 сарын хугацаатай 1 хувийн хүүтэй 50.0 сая төгрөгийн зээл олгосон ба энэ нь Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 хэсэгт “Компани эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээг дүрмээрээ хязгаарлаж болно” гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулахгүй байх талаар зөвлөмж өгөх.

2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал:


1. Тус байгууллага 2016 онд НӨАТ төлөгч болох шаардлагыг зөвхөн байрны түрээсийн орлого 33.9 сая төгрөгөөр хангасан байна. Татварын шалгалтаар акт тавигдах эрсдэл өндөр байна.
2. БНСУ-ын төслийн зээл хаагдаж байгаатай холбогдон цаашид тасралтгүй үйл ажиллагаа явуулах эсэх нь эргэлзээтэй байна.

2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

БНСУ-ын хөдөө аж ахуйн төслийн загвар аж ахуйн төсөл 2018 оны 7 дугаар сард хаагдаж дуусах ба төслийн гүйцэтгэлийн тайланг шалгах.

2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл:

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв ТӨААТҮГ-ын тайлант оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 252.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11.3 сая төгрөгийн алдааг залруулж, 9.9 сая төгрөгийн зөрчилд албан шаарлага өгч, 230.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн.



2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас 3 зөвлөмж өгсөн нь 2017 оны санхүүгийн тайланд хэрэгжүүлсэн байна.

2.16 Материаллаг байдал:

Материаллаг байдлын суурийг “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын нийт зардлыг суурь болгож түүний 2 хувиар тооцож 6.4 сая төгрөгөөр төлөвлөлтийн үе шатанд тооцсныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.17 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**Асуудал 1. Санхүүжүүлэгч
байгууллага КОПИА МОНГОЛ ТӨВ-тэй
тооцоо нийлж тайлангын асуудалгүй
болох талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Копиа монгол төвөөс 3 удаагын төсөл авч хэрэгжүүлж тайлант онд 1 төсөл хаагдаж 1 төслийн санхүүжилт хийгдэж дууссан байна.

Гэвч санхүүжүүлэгч байгууллагын шаардсан гүйцэтгэлийн тайлан, анхан шатны баримтыг цаг хугацаанд өгч байгаагүй байна.

Эрсдэлүүд

Дээрх шалтгааны улмаас санхүүжүүлэгч байгууллага хууль хяналтын байгууллагад гомдол гаргах магадлал өндөр, түүнчлэн хоёр орны найрамдалд цав суух

ҮАГ-ын зөвлөмж

Санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж тайлангын болон тооцооны өргүй болох.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор биелүүлэх

Гүйцэтгэх захирлын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

**Асуудал 2. Дүрмийн сангийн
бүртгэлийн талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн тайланд эзний өмчийн дүн 1,180.8 сая төгрөгөөр тайлагнагдсан ба тайланд онд 219.9 сая төгрөгөөр нэмэгдсэнийг улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй.

Эрсдэлүүд

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сан дутуу илэрхийлэгдсэн байх

ҮАГ-ын зөвлөмж

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн өөрчлөлтийг өөрчлөлт гарсан тухай бүрт нь өөрчлөлт оруулах, орсон өөрчлөлт бүрд төрийн өмчийн хорооны шийдвэртэй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор биелүүлэх

Гүйцэтгэх захирлын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

**Асуудал 3. Түрээсийн орлого олж
байгаа талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

ХААҮШУОНТ ТӨААТҮГ-ын байрлаж буй байрны сул хэсгийг түрээслүүлж тайлант онд 33.3 сая төгрөгийн орлогоос 9.9 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлээгүй, санхүүгийн байдлын тайланд өглөг үүсгээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 102 тоот тогтоолын 2 хэсгийг дагаж мөрдөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор биелүүлэх

Эрсдэлүүд

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол дагаж мөрдөөгүй

Гүйцэтгэх захирлын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 4. Үндсэн хөрөнгө, Бараа материалыг санхүүгийн программд бүртгэж байгаа талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Бараа материал дансанд 11.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байна.

Мөн бараа материал болон үндсэн хөрөнгийн код эмх замбараагүй, ангилалын дагуу биш байна.

Эрсдэлүүд

НББ-ийн бодлогоо баримтлаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн бодлогын баримт бичигт заасан аргаар бүртгэж санхүүгийн програмдаа оруулах нь зүйтэй байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор биелүүлэх

Гүйцэтгэх захирлын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 5. Мөнгөн хөрөнгийн бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтын шалгалтаар дэмжих, кассын зарлагын баримт, мөнгө олгохыг хүссэн баримт аль нэг нь дутуу 1.0 сая төгрөг байна

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн бодлогын баримт бичгээ мөрддөг байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор биелүүлэх

Эрсдэлүүд

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Гүйцэтгэх захирлын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.



Асуудал 6. Үндсэн үйл ажиллагааны чиглэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Компанийн гэрчилгээнд зааснаар үндсэн үйл ажиллагааны чиглэл зөвхөн сургалт явуулах гэж заасан боловч тайлант онд 2 сарын хугацаатай 1 хувийн хүүтэй 50.0 сая төгрөгийн зээл олгосон ба зээлийн эргэн төлөлт хийгдэж ямар нэгэн асуудал үүсээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Компанийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулахгүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор биелүүлэх

Эрсдэлүүд

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Гүйцэтгэх захирлын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ХААУШУОНТ ТӨААТҮГ

2017 оны 12-р сарын 31-ны өдөр

(Аж ахуйн нэгжийн нэр)

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	60,727,120.90	83,012,672.77
1.1.2	Дансны авлага	902,691.24	194,580.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	23,279,348.00	33,229,628.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	41,889,200.00	40,291,900.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	126,798,360.14	156,728,780.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	724,515,008.30	913,785,005.40
1.2.2	Биет бус хөрөнгө	933,333.33	733,333.33
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	120,655,650.00	192,939,108.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	846,103,991.63	1,107,457,446.73
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	972,902,351.77	1,264,186,227.51
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	578,261.86	578,261.85
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		293,107.76
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	162,544,850.00	233,231,008.00
2.1.1.9	Нөөц \ өр төлбөр\		
2.1.1.10	Бусад богино хунгацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	163,123,111.86	234,102,377.61
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц \ өр төлбөр\		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	1,180,795,037.54	1,400,737,501.74
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа	1,180,795,037.54	1,400,737,501.74
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	75,771,555.00	75,771,555.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	976,893.60	976,893.60
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(447,764,246.23)	(447,402,100.45)
2.3.10			-
2.3.11	Эздийн өмчийн дүн	809,779,239.91	1,030,083,849.89
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	972,902,351.77	1,264,186,227.50



АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ХААУШУОНТ ТӨААТҮГ

2017 оны 12-р сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	193,763,904.44	232,212,536.24
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	193,763,904.44	232,212,536.24
4	Түрээсийн орлого	33,900,000.00	33,300,000.00
5	Хүүний орлого	3,391,949.80	3,766,619.95
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	96,285,245.62	38,491,528.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	180,708,029.32	85,375,168.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	141,553,787.93	228,090,542.63
11	Санхүүгийн зардал	96,454.07	
12	Бусад зардал	4,656,376.00	
13	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	20,614,807.20	218,624.66
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		14,821,771.56
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		8,524,473.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	20,941,259.74	820,896.78
19	Орлогын татварын зардал	867,082.85	458,751.00
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	20,074,176.89	362,145.78
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	20,074,176.89	362,145.78
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ХААҮШУОНТ ТӨААТҮГ

(Аж ахуйн нэгж,
байгууллагын нэр)

2017 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,180,795,037.54	75,771,555.00	976,893.60	(467,838,423.12)	789,705,063.02
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	1,180,795,037.54	75,771,555.00	976,893.60	(467,838,423.12)	789,705,063.02
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				20,074,176.89	20,074,176.89
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-	-
9	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,180,795,037.54	75,771,555.00	976,893.60	(447,764,246.24)	809,779,239.91
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	1,180,795,037.54	75,771,555.00	976,893.60	(447,764,246.24)	809,779,239.91
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				362,145.78	362,145.78
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт	219,942,464.20				219,942,464.20
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,400,737,501.74	75,771,555.00	976,893.60	(447,402,100.45)	1,030,083,849.89



АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХААҮШУОНТ ТӨААТҮГ

2017 оны 12-р сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	318,209,016.86	372,728,222.24
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	4,063,000.00	1,257,195.00
	Эрхийн шимтлэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	314,146,016.86	371,471,027.24
1.2.	Мөнгөн зарлагын дүн (-)	296,185,339.50	281,417,914.97
	Ажиллагчдад төлсөн	103,084,833.00	100,536,970.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	26,715,121.28	25,643,960.09
	Бараа материал худалдан авахад төлсөн	8,227,750.00	5,967,110.00
	Ашиглалтын зардалд төлсөн	20,688,832.00	19,341,375.50
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,171,600.00	9,341,780.00
	Татварын байгууллагад төлсөн	12,826,683.97	9,724,252.00
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	122,470,519.25	110,862,467.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	22,023,677.36	91,310,307.27
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,391,949.80	66,266,519.95
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		62,499,900.00
	Хүлээн авсан хүүний орлого	3,391,949.80	3,766,619.95
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	35,829,000.00	135,509,900.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,549,000.00	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	33,280,000.00	
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		135,509,900.00

01

ТӨРИЙН АУДИТ БУСАД ОРГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,437,050.20)	(69,243,380.05)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	43,647.69	218,624.66
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(10,369,725.15)	22,285,551.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	71,096,846.05	60,727,120.90
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,727,120.90	83,012,672.77

